

REACH

Small and Medium Enterprise Access to Credit

REACH САР ТУТМЫН СОНИН

2016 оны 12 сар №8



ЭНЭ УДААГИЙН ДУГААРТ:

1. REACH Төслийн 11 Сарын Онцлох Үйл Явдлуудаас
2. Амжилтын Түүх
3. Таны Мэдлэгт Булан
4. Зээлийн Боловсрол
5. Монгол Улсад Хэрэгжиж Буй Олон Улсын Байгууллагуудын Төслүүд
6. Зээлийн Зуучлал
7. Салбаруудад Болсон Онцлох Үйл Явдлуудаас
8. Бизнес Зөвлөгөө
9. REACH Төслийн 2017 оны 1 Сард Зохион Байгуулах Үйл Ажиллагааны Хөтөлбөр


ХОЛБОО БАРИХ:

REACH Төслийн оффис:


№ 703, МАКС Тауэр,
Жуулчины гудамж 4-4, Чингэлтэй
дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

 +(976) 7722-2210 reach@dsmongolia.org www.dsmongolia.org www.facebook.com/REACHProject**Баян-Өлгий Оффис:**


№ 302 тоот, Гурван-Эрдэнэ Төв
5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг

 Утас: 7042-2080**Дорнод Оффис:**


№ 11 тоот, Ольхон Худалдааны Төв,
9-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг

 Утас: 7058-2030**Дундговь Оффис:**

№ 205 тоот, Мандал Шилтгээн ХХК-ийн
байр, 7-р баг, Бага тойруу, Сайнцагаан сум,
Дундговь аймаг

 Утас: 7059-2209**Сэлэнгэ Оффис:**

№ 1 тоот, Алтан Булаг Төв
Сүхбаатар сум, 2-р баг, Сэлэнгэ аймаг

 Утас: 7036-3440

1. REACH ТӨСЛИЙН 11 САРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУДААС

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй REACH төсөл жижиг, дунд бизнесүүдийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлж, зээлийн бүтээгдэхүүнд хамрагдах чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор сар бүр тодорхой сэдвүүдийн хүрээнд ажил хэрэгч уулзалт зохион байгуулж байна. Харин өнгөрөгч 11 сард Улаанбаатар хотод болон Налайх дүүрэгт тус уулзалт хэлэлцүүлэг амжилттай зохион байгуулагдлаа.

НАЛАЙХ ДҮҮРЭГ /2016.11.17/

“Жижиг, дунд бизнесүүдийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авах боломж” сэдэвт ажил хэрэгч уулзалтыг REACH төсөл Налайх дүүргийн ЖДҮДТөвтэй хамтран зохион байгуулав. Энэхүү уулзалтаар Хаан Банкны Бизнес хөгжил хариуцсан менежер С.Батбаяр, арилжааны банкны зээлийн бүтээгдэхүүн болон зээл авахад банкны шаардлагыг хэрхэн хангах талаар цогц мэдээлэл өгсөн бол ХасБанкны төв салбарын Бизнес менежер А.Батсүх, бага хүүтэй Олон улсын болон жижиг дунд үйлдвэрийг дэмжих төсөл хөтөлбөрийн зээл, тус төслийн зээлд хамрагдахад ямар шалгуур тавигддаг, хэрхэн хамрагдах талаар мэдээлэл өгсөн нээлттэй хэлэлцүүлэг болж өндөрлөө.



УЛААНБААТАР ХОТ /2016.11.29/

Улаанбаатар хотод болсон “БИЗНЕСИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖУУД” сэдэвт уулзалт хэлэлцүүлэгт Гадаад худалдаа, МАА, Газар тариалан, Чулуун мебель үйлдвэрлэл, Харилцаа холбоо, Даатгал, Барилга, Хүнсний үйлдвэрлэл худалдаа, Үйлчилгээ зэрэг салбаруудын 50 аж ахуйн нэгж байгууллагын захирал, менежер, нягтлангууд оролцлоо. Энэхүү уулзалтаар Монгол улсад хэрэгжиж байгаа олон улсын хөнгөлөлттэй зээлүүд тэр дундаа зах зээл дээр эрэлттэй байгаа АХБ-ны ХАА, Хөдөөгийн Хөгжлийн төсөл мөн Гадаад худалдааны санхүүжилт буюу олон улсын зах зээл дээр бизнес эрхлэгчдэд хамгийн тохиромжтой санхүүжилтийн арга хэрэгслүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөөс эдгээр санхүүжилт нь бусад санхүүжилтийн хэлбэрүүдээс юугаараа илүү давуу талтай зэрэг мэдээллүүдийг холбогдох байгууллагуудын мэргэжилтэнүүд өгч, дэлгэрэнгүй асуулт хариулт бүхий хэлэлцүүлэг боллоо.

АМЖИЛТЫН ТҮҮХ



Бизнесийн салбар:
Ресторан

Бизнесийн нэр:
“Энхжин” ресторан

Бизнес эрхлэгчийн овог, нэр:
Дашхоролын Цэрэнчимэд

“REACH” сар тутмын сонин Монгол улсын өнцөг бүрд бизнесээ амжилттай өргөжүүлж буй жижиг, дунд бизнесүүдийн амжилтын түүхийг уншигч та бүхэнтэй хуваалцдаг билээ. Энэ удаад бид Дундговь аймгийн амжилттай яваа нэгэн залуу бизнесийн түүхээс хуваалцаж байна.

Дундговь аймагт АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй REACH төсөл хэрэгжиж эхэлснээс хойш маш олон жижиг, дунд бизнесүүд төслийн түслэмжтайгаар төслийн зээлийн зуучлалын үйлчилгээнд хамрагдаж бизнесээ өргөжүүлэн, ашиг орлогоо нэмэгдүүлж улмаар ажлын байр бий болгож, аймгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байна. Үүний нэг жишээ бол “Энхжин” рестораны бизнес юм.

Залуу бизнес эрхлэгч Д. Цэрэнчимэд анх 2008 онд 4 ажилтантай “Цайны газар” нэртэйгээр нийтийн хоолны газар нээж, 2009 онд “Хишиг Өгөөмөр” ХХК-г байгуулж цайны газраа “Энхжин” ресторан кафе болгож өргөжүүлжээ. “Энхжин” ресторан бол аймгийн төвд байрлалтай хэдий ч зам дагуу биш тул зөвхөн мэддэг, танил хүмүүс зорьж ирж үйлчлүүлдэг байна. Тиймээс Цэрэнчимэд үйл ажиллагаагаа өргөжүүлж, Өмнөговь явах зам дагуу байрлалтай урагшаа, хойшоо явах тээврийн жолооч, жуулчид гээд

бүгд орох боломжтой тав тухтай салбараа нээхээр төлөвлөжээ.

REACH төслийн зээлийн зуучлалын үйлчилгээний талаар сонссон Д. Цэрэнчимэд шинэ салбараа нээхэд шаардлагатай санхүүжилтийг REACH төслөөр дамжуулан банкнаас зээл авахаар шийдэж, REACH төсөл түүний хүсэлтийн дагуу банкнаас зээл авахад шаардлагатай бичиг баримтын бүрдүүлэлт, зээлийн тооцоолол, аль банканд хандаж болох зэрэг бүхий л зөвлөгөөг өгсөн юм. Үүний үр дүнд “Энхжин” ресторан хүссэн санхүүжилтээ маш хурдан хугацаанд авч шинэ салбараа нээгээд зогсохгүй шинээр 6 ажлын байр бий болгосон юм.

REACH төсөл Баян-Өлгий, Дундговь, Дорнод, Сэлэнгэ аймагт хэрэгжиж байгаа бөгөөд орон нутгийн жижиг, дунд бизнесүүдэд шаардлагатай бизнесийн зээлийн бүтээгдэхүүнийг авах боломжийг бүрдүүлж, тэдний санхүүжилт авах үйл явцыг хурдасгаж, бизнесээ амжилттай өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлсээр байна.



3. ТАНЫ МЭДЛЭГТ БУЛАН

Бизнес санаа нь эргэн тойронд чинь байгаа хангагдаагүй хэрэгцээнээс хэрэгцээ гарч л байгаа бол түүнийг бизнес болгоход хамгийн амархан гэж ойлгуулах. Хийж чаддаг зүйлээ биш хэрэгцээтэй зүйлийг л хий тэгвэл энэ бизнес.

Ашиглагдахгүй байгаа нөөц үр чадвараас өөрт байгаа нөөц бололцоо үр чадвараа ашиглаад бизнес хийж болно. Жишээлбэл: Олон жил үслэг эдлэлийн үйлдвэрт ажилласан туршлагатай хүн байлаа гэж бодоход энэ чиглэлээрээ бизнес явуулж болох. Энд илүү олон жишээг дурдах боломжтой юм.

- Хаягдал ашиглах Жишээлбэл хог дээр хаягдаад эсээд муудсан зүйлээс газ гаргаж авах гэх мэт жишээг ярьж хаягдал ашиглах нь түүхийн эдийн зардал бага шаарддаг давуу талтай ч гэж хэлж болно. Мөн олдоц сайтай гэх мэт.
- Бусад нийгэм болон хууль эрх зүйн таатай орчиноос Төр засгийн зүгээс анхааралдаа авсан, эсвэл нийгэмд нүүрлээд байгаа аюул эсвэл нийгэмд нэн даруй хэрэгцээтэй байгаа болон ач холбогдолтой зүйлс Энд төрөл бүрийн жишээ дурдаж болно. Агаарын бохирдол, хог боловсруулах үйлдвэр, шахмал түлш, жижиг дунд бизнесийг дэмжих жил болгон зарлах гэх мэт төрийн зүгээс дэмжлэг авах бололцоотой бүхий л бизнес байж болох.

Хүн өөрийнхөө мэдрэмжийг анзаарч байх хэрэгтэй. Өөрийн оюун санаанд зурвас бодогдсон тэр зүйл нь магадгүй сайн бизнесийн санаа ч байж болох. Түүнчлэн бидэнд хэдэн ч төрлийн бизнес санаа төрж болно.

Санамсаргүй нээлт гэж байдаггүй
Санамсаргүй нээлт гэдэг бол
Сайтар мэдрэгдсэн оюун ухааны үр дүн.

WWW.BIZGUIDE.MN



Бизнес тэй холбоотой бүхий л мэдээллийг
www.bizguide.mn-ээс аварай

БИЗНЕС САНААГ СОНГОХДОО АНХААРАХ ЗҮЙЛС

- » Надад хамгийн тохирох бизнесийн санаа
- » Хамгийн бага рисктэй байх
- » Хамгийн тогтвортой байх
- » Хамгийн их үр ашигтай байх
- » Бизнесийн газрын зураг

Таны бизнес санаанд нэмэр болгохоор дэлхийд хамгийн ашигтай байгаа бизнесүүдийн талаарх мэдээллийг орууллаа.

СҮҮЛИЙН 10 ЖИЛИЙН ТОП-10 БИЗНЕС

1. Ня-Бо бүртгэл ба аудит
2. Гоо сайхан ба хувь хүнд хандсан үйлчилгээнүүд
3. Компьютерийн зөвлөгөө, үйлчилгээ
4. Конференц зохион байгуулах, төлөвлөлт хийх, бизнесийн зөвлөгөө
5. Хүүхэд ба өндөр настны асрах үйлчилгээ
6. Эрүүл мэнд ба бялдаржуулах клубууд
7. Гэр цэвэрлэх ба дуудлагын үйлчилгээ
8. Үл хөдлөх хөрөнгийн үйлчилгээ
9. Богино хугацаанд ажил олгох агентлаг
10. Аялал жуулчлал

4.ЗЭЭЛИЙН БОЛОВСРОЛ

БЭЛЭН МӨНГӨНИЙ УРСГАЛАА ХЭРХЭН ЗӨВ УДИРДАХ ВЭ?

Өсч хөгжиж байгаа компанийн хувьд бэлэн мөнгөний орлого, зарлагаа зөв удирдах нь нэн чухал байдаг. Хэрэглэгчээс борлуулалт, үйлчилгээний төлбөрөө авч нийлүүлэгч, ажилтнууддаа ажлын хөлсийг төлөх хоорондын хугацааны зөрүү гол асуудал болдог ба түүнийг шийдэх нь мөнгөн урсгалын зөв зохион байгуулалт юм. Энгийнээр хэлбэл мөнгөн урсгалыг удирдах гэдэг нь гадагшаа төлөх төлбөрөө аль болох орой, харин танд орж ирэх орлогыг аль болох хурдан авах зорилготой.

Дараа жилийн бэлэн мөнгөний урсгалаа урьдчилж төлөвлөхийг хичээ, хэрэв таамаглахад түвэгтэй байвал ядаж дараа долоо хоногийн мөнгөн урсгалаа төлөвлөөд үз. Ингэж төлөвлөж харснаар бэлэн мөнгөний дутагдлыг урьдчилан харж, шийдвэрлэх боломжтой болно.

Мөнгөн урсгалын төлөвлөлт нь ирээдүйг таамаглах хэцүү ажил гэж бодож байна уу? Ердөө л өмнөх түүхэн мэдээлэл дээрээ үндэслэн таамаглал гаргахад л болно. Ирэх жил нийлүүлэгч рүү хэдий захиалга өгөх, төлбөрийг нь хэдий хийх үү, манай худалдан авагчид хэдий хугацаанд төлбөрөө төлдөг гэх мэтчилэн. Ингэж төлөвлөхдөө авлагууд одоогийнхоо түвшинд цаг хугацаандаа хийгдэх үү, төлбөр төлөлтөө хэдий хугацаанд оройтуулж болох уу, үндсэн хөрөнгийн худалдан авалт хийгдэх үү, зээлийн хүү, үндсэн зээлийн төлөлт, улирлын чанартай борлуулалтын хэлбэлзэл зэргээ сайн тооцоолох хэрэгтэйг анхаараарай.

Эхний ээлжинд танд байгаа бэлэн мөнгө болон удахгүй орж ирэх авлагуудаа бүртгээрэй. Энэ мэдээллийг та худалдааны менежер, авлага хариуцсан нягтлан, санхүүгийн албанаасаа авах боломжтой. Хэдий хэмжээний мөнгө хэзээ орж ирэх вэ гэдгийг тодорхойлно.

Үүний дараа анхаарах чухал хэсэг бол зарцуулах мөнгөний хэмжээ, огноо, юунд зарцуулах гэж байгаа утгыг сайтар тодорхойлох хэрэгтэй. Зардал бүрийнхээ ард утгыг нь тодорхойл, худалдан авалт, цалин урамшууллын зардал, татвар төлөлт, үйлчилгээний хураамж, хангамжийн материал, зээлийн төлбөр, шатахууны зардал гэх мэт.

Мөнгөн урсгалын төлөвлөлт гаргах нь ирээдүйгээ төлөвлөх бизнес төлөвлөгөө болон зорилго зорилтаа тодорхойлохын дараа бичигдэх чухал төлөвлөлт юм.

АВЛАГЫН ЭРГЭЦЭЭ САЙЖРУУЛАХ

Хэрэв таны хийсэн борлуулалтын төлбөр тэр даруйдаа хийгддэг бол танд мөнгөний урсгалтай холбоотой асуудал гарахгүй. Гэхдээ тэгэх боломжгүй бол авлагаа цуглуулах хугацаагаа бууруулж, мөнгөн хөрөнгөө зөв удирдах л хэрэгтэй болно. Үндсэн санаа нь түүхий эд материал бүтээгдэхүүнд хувирах, бараа бүтээгдэхүүн борлуулагдах, борлуулалтын төлбөр орж ирэх хугацаануудыг аль болох хурдасгахад л оршино. Үүнийг хэрэгжүүлэх хэд хэдэн арга техник байдаг :

- Харилцагч төлбөрөө хурдан хийвэл тодорхой хямдрал, урамшууллыг санал болгох
- Харилцагч захиалга өгөхдөө урьдчилгаа төлбөр төлөхийг санал болгох
- Шинэ харилцагчдаа урьдчилан төлбөрөө хийхийг санал болгох
- Агуулахад удаан хадгалагдсан, эргэлт удаантай бараанаас аль болох эртхэн салах
- Хугацаандаа төлөгдөхгүй байгаа авлагуудыг байнга хянаж байх
- Төлбөрөө цаг хугацаандаа төлдөггүй харилцагч нартайгаа баримтлах бодлого хэрэгжүүлэх

ӨГЛӨГИЙГ УДИРДАХ НЬ

Борлуулалтын өндөр өсөлтийн үед зарим асуудлыг анзаарахгүй өнгөрөх тохиолдол байдаг. Ялангуяа хурдтай хөгжиж байгаа компанид зардлаа маш сайн хянах хэрэгтэй. Борлуулалтын орлого өссөнөөр өөрсдийгөө тайвшруулж болохгүй. Ихэнх тохиолдолд зардал борлуулалтаас илүү хурдтай өсдөг. Мөнгийг үр ашигтай зарцуулах зөвлөгөө :

- Төлбөр төлөх эцсийн хугацааг сайн ашигла. 30 хоногийн дотор төлөх нөхцөлтэй бол 15 хоногийн дотор төлөх шаардлагагүй
- Нийлүүлэгчидтэйгээ санхүүгийн нөхцөл байдлаа хуваалцаж бай. Хэзээ нэг цагт төлбөрөө хугацаанаас нь хоцроох шаардлага гарахад тэд танд итгэж, таныг ойлгох болно
- Нийлүүлэгчийн төлбөрийн нөхцлийг сайтар судла
- Хямд үнэ үргэлж зөв сонголт байдаггүй. Заримдаа уян хатан төлбөрийн нөхцөлтэй нийлүүлэгчийг сонгох нь таны мөнгөний урсгалыг сайжруулахад нөлөөлж чаддаг

БЭЛЭН МӨНГӨНИЙ ГАЧИГДЛЫГ ДАВАН ТУУЛАХ НЬ

Зарим үед бизнесүүд бэлэн мөнгөний дутагдалд орж, өр төлбөрөө төлөхөд хүндрэлтэй асуудалтай тулгардаг. Энэ нь бизнесийн уналт гэж ойлгож болохгүй, ердөө ирээдүйгээ зөв тааварлаж чадаагүйтэй холбоотой. Бэлэн мөнгөний дутагдалыг удирдахад хамгийн чухал нь аль болох эрт мэдэж, арга хэмжээ авах нь чухал. Банк зээл өгөхдөө санхүүгийн чадавхитай байхыг шаарддаг. Тэд танд хэрэгцээ нь гарсан үед биш тэрнээс өмнө л өгөх боломжтой байдаг. Мөнгөний дутагдалд орсон гэдэг нь таныг төлөвлөлтөө сайн хийж чадаагүй гэсэн мэссэжийг өгдөг ба энэ нь банкинд найдваргүйг зээлдэгч мэт харагдуулдаг.

5. МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖИЖ БҮЙ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСЛҮҮД

ГОЛОМТ БАНКИНД ОЛГОГДОЖ БАЙГАА KFW БАНКНЫ ТӨСЛИЙН ЗЭЭЛ



Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын KFW Банкны эх үүсвэрээр Монгол улсын экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих төслийн зээл.



ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ:

Экспорт болон импортыг орлох чиглэлийн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтанд буюу тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх

ДАВУУ ТАЛ

- Экспортын чиглэлийн үйлдвэрийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, тоног төхөөрөмжийн санхүүжилтэнд тохиромжтой.
- Бусад төслийн зээлүүдтэй харьцуулахад шийдвэрлэгдэх хугацаа, ажиллагаа бага бөгөөд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шаардлагагүй.

САНХҮҮЖИЛТИЙН ХЭМЖЭЭ:

250,000 хүртэл EUR буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөг

ЗЭЭЛИЙН ХҮҮ ЖИЛЭЭР:

Төгрөг 15,8 % жил
EUR 8.5% жил

ЗЭЭЛИЙН ХУГАЦАА:

5 хүртэлх жил

ЗЭЭЛ ХҮСЭГЧИД ТАВИГДАХ НЭМЭЛТ ШААРДЛАГА:

- Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага
- Зээл хүсэгч нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт түүний үр ашигтай нөхцөлийг хангасан ажлын байр шинээр бий болгож байх
- 1 жилээс дээш хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх
- Зээл хүсэгч нь өмнөх улиралын тайлан балансаа гаргаж, татварын албаар баталгаажуулсан байх
- Тогтсон хаяг дээр үйл ажиллагаа явуулдаг байх
- Эрхзүйн бүрэн чадамжтай байх
- Барьцаанд тавих үлд хөдөлх хөрөнгөтэй байх
- Бусад банк болон банк бус санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх

Жич: KFW Банкны төслийн зээлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг REACH төслөөс авах боломжтой



6. ЗЭЭЛИЙН ЗУУЧЛАЛ



ЗЭЭЛИЙН БОДИТ ӨРТӨГ ГЭЖ ЮУ ВЭ?

“Бодит үйлчилж буй хүү”

“Бодит үйлчилж буй хүү” гэж хүү бодох давтамжийн нөлөөг оруулсны дараах зээлд төлж буй эсвэл хөрөнгө оруулалтанд авч буй хүүг хэлнэ.

Монгол банкны Ерөнхийлөгчийн 2013 А-236 дугаар тушаалаар батлагдсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 3.1.2-т заасны дагуу Банк нь зээлийн бүтээгдэхүүний ерөнхий танилцуулга, зарласан хүү, зээлийн бодит өртөг, шимтгэл, хураамжийн мэдээллийг үнэн зөв гарган олон нийтэд мэдээлнэ гэсэн байдаг.

Бодит өртөг тооцох аргачлал:

Зээлтэй холбоотой зээлдэгчийн төлж буй аливаа нэмэлт үйлчилгээний зардал, шимтгэл, хураамж зэргийг тооцон зээлдэгчийн төлж байгаа хүү дээр нэмсэн дүнг зээлийн бодит өртөг гэнэ.

Жишээ нь:

Сарын 1.7%-ийн хүүтэй, 50 сая төгрөгийн бизнесийн зээлийг 3 жилийн хугацаатэй, эргэн төлөлтийг сар бүр хийх нөхцөлтэй авах тохиолдолд бодит өртөг тооцё.

Үүнд:

Зээлийн өргөдлийн хураамж 10.0₮ (нэг удаа өргөдөл хүлээн авахад.)

Зээлийн үйлчилгээний шимтгэл зээлийн дүнгийн 1% (нэг удаа зээл олгоход) бол зээлийн үйл ажиллагаатай холбоотой 510.0₮ зардал гарч байна.

Зээлийн бодит өртгийг тооцвол 21.14% болж байна

Зээлийн эргэн төлөлтийн хуваарь зохиох 2 арга

Банкууд зээлдэгчтэй зээлийн гэрээ байгуулах үедээ зээлийн эргэн төлөлтийн хуваарийг хавсралтаар баталдаг бөгөөд үүндээ зээлийн хугацаанд тухайн зээлдэгч сар бүр зээл болон зээлийн хүүнд хэдэн төгрөг төлөхийг зааж өгдөг.

Үүндээ 2 төрлийн арга хэрэглэдэг.

Нэгд нь зээл болон хүүгийн төлбөр нь сар бүр тэнцүү байдаг бол нөгөө аргын хувьд сар бүр төлөх үндсэн зээлийн төлбөрийг нь сар бүр тэнцүү байхаар тооцож үүнтэй холбоотойгоор зээл болон хүүгийн төлбөр нь сараас сард буурч байхаар тогтоодог юм. Бага дүнтэй зээлийн хувьд ЭТХ-ийг аль ч аргаар нь зохиоход нийт зээлтэй байх хугацаанд төлөх хүүгийн төлбөрт зөрүү бараг гардаггүй бөгөөд богино хугацаатай зээл дээр ч мөн зөрүү бага гардаг.

Харин 10 эсвэл 15 жилээр төлөвлөж байгаа, урт хугацаат зээл дээр эрс ялгаа гарч ирдэг.

Үүнийг нэгэн жишээгээр тайлбарлая. Бат нь “AAA” болон “BBB” банкнаас 5 сая төгрөгийг 1 жил 6 сарын хугацаатайгаар сарын 2 хувийн хүүтэй зээл авахаар 2 банкаар 2-уулангаар нь тооцоо хийлгүүлж үзжээ.

Зээлийн хэмжээ: 5000000		Зээлийн хугацаа: 18 сар		зээлийн хүү: 2%	
“AAA” банкны зохиож өгсөн хувицбар					
№	Сар бүр зээл төлөх дүн	сард бодогдох зээлийн дүн	Үлдсэн зээл төлөх дүн	Зээлийн үлдэгдэл	
1	333,510	100,000	233,210	4,760,490	
2	333,510	95,320	238,191	4,528,309	
3	333,510	90,566	242,944	4,283,365	
4	333,510	85,707	247,803	4,027,561	
5	333,510	80,751	252,759	3,764,802	
6	333,510	75,696	257,814	3,496,988	
7	333,510	70,540	262,971	3,224,017	
8	333,510	65,280	268,230	2,945,787	
9	333,510	59,916	273,595	2,662,192	
10	333,510	54,444	279,067	2,374,126	
11	333,510	48,863	284,648	2,081,478	
12	333,510	43,170	290,341	1,784,137	
13	333,510	37,363	296,148	1,482,099	
14	333,510	31,440	302,071	1,175,068	
15	333,510	25,398	308,112	863,006	
16	333,510	19,236	314,274	545,732	
17	333,510	12,951	320,569	224,072	
18	333,511	6,539	326,972	0	
Нийт		1,003,189			

“BBB” банкны зохиож өгсөн хувицбар					
	сард бодогдох зээлийн дүн	Үлдсэн зээл төлөх дүн	Сар бүр зээл төлөх дүн	Зээлийн үлдэгдэл	
	100,000	277,778	377,778	4,722,222	
	94,444	277,778	372,222	4,444,444	
	88,889	277,778	366,667	4,166,667	
	83,333	277,778	361,111	3,888,889	
	77,778	277,778	355,556	3,611,111	
	72,222	277,778	350,000	3,333,333	
	66,667	277,778	344,444	3,055,556	
	61,111	277,778	338,889	2,777,778	
	55,556	277,778	333,333	2,500,000	
	50,000	277,778	327,778	2,222,222	
	44,444	277,778	322,222	1,944,444	
	38,889	277,778	316,667	1,666,667	
	33,333	277,778	311,111	1,388,889	
	27,778	277,778	305,556	1,111,111	
	22,222	277,778	300,000	833,333	
	16,667	277,778	294,444	555,556	
	11,111	277,778	288,889	277,778	
	5,556	277,778	283,333	0	
		950,000			

“AAA” банк нь сар бүр тэнцүү төлөлттэй байхаар, “BBB” банк сар бүр буурч байхаар эргэн төлөлтийн хуваарийг дараах байдлаар зохиож өгсөн байна.

7. САЛБАРУУДАД БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУДААС

БАЯН-ӨЛГИЙ САЛБАР

Баян-Өлгий аймгийн Засаг Даргын Тамгын Газрын зүгээс “НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ-2016” форум 2016 оны 11 сарын 21-нд зохион байгуулагдаж, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран зохион байгуулж буй REACH төсөл уг форумын ерөнхий зохион байгуулагчаар форумд оролцлоо.

Баян-Өлгий аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан уг томоохон хэмжээний форумд холбогдох төрийн байгууллагууд, хувийн хэвшил, банкууд болон олон улсын төсөл хөтөлбөрүүдийн төлөөлөл бүхий нийт 300 хүн оролцож, оролцогч талуудын зүгээс салбар бүрийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын зорилт, тулгамдаж буй асуудлын талаар нээлттэй хэлэлцсэн үр дүнтэй форум болж өндөрлөө.



ДОРНОД САЛБАР

Дорнод салбар “Дорнод Аялал Жуулчлалын Нэгдэл”-тэй хамтран “Санхүүгийн боловсрол олгох нь” сургалтыг 2016.11.25 –ны өдөр амжилттай зохион байгууллаа. Дорнод аймаг нь зүүн бүсийн томоохон аймаг бөгөөд аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой юм. Цаашид тус нэгдэлтэй хамтран аялал жуулчлалын бизнес эрхлэгчидтэй ажил хэрэгч уулзалтууд болон сургалт семинараа хамтран зохион байгуулахаар төлөвлөөд байна.



ДУНДГОВЬ САЛБАР

Дундговь аймагт 2016 оны 11 дүгээр 3-4 өдрүүдэд “Нэг говь нэг зорилго” нэртэй Говийн бүсийн өрсөлдөх чадварын чуулган боллоо. Энэхүү чуулган уулзалтыг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, Конрад-Аденауэрын сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим Дундговь аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж 300 гаруй төлөөлөгчид оролцов. Чуулганд Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгуудын удирдлага, төлөөллүүд, АНУ-ын ОУХА-ийн REACH төсөл, орон нутгийн тэргүүлэх салбарууд хувийн хэвшлийг дэмжих бодлого, хөрөнгө оруулалтын чиглэлээр тус тус илтгэл тавьлаа.



СЭЛЭНГЭ САЛБАР


Сэлэнгэ салбар 2016.11.11-нд Жижиг, дунд бизнесүүдийн зээлийн батлан даалтын санд хамрагдах боломж сэдвээр ажил хэрэгч уулзалт зохион байгуулж илтгэгчид ОУ-ын байгууллагуудын төслийн зээл, батлан даалтын сангийн талаар цогц мэдээлэл хүргэхээс гадна аймгийн удирдлагуудад жижиг, дунд бизнесүүдийн тулгамдаж буй асуудлуудын талаар мэдээлэл хүргэсэн нээлттэй хэлэлцүүлэг болж өндөрлөө.



8. БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

БИЗНЕС ЭРСДЭЛГҮЙ БАЙХ НЬ БИЗНЕСИЙН МОДЕЛОО ЗӨВ ТОДОРХОЙЛОХООС ЭХЭЛНЭ

Бизнес модель гэдэг нь товчхондоо байгууллага хэрэглэгчид хэрхэн үнэ цэнийг бүтээж, түгээж, эргээд өөртөө хэрхэн үнэ цэнэ олж авч буйг харуулах нэгдсэн тогтолцоо юм. Энэхүү тогтолцоог хангах Бизнес моделийн концепци, аргачлалыг дэлхий нийтээрээ ашиглаж байна.



Бизнес модельд таний бизнест зайлшгүй хэрэглэгддэг 9 бүрдүүлэгч хэсэг буюу бизнесийн ойлголтуудыг нэгтгэсэн байдаг ба эдгээрийн логик уялдааг харуулж өгсөнөөрөө онцлог юм. Үүнд :

1. Хэрэглэгчийн сегментүүд - Компанийн хүрч үйлчлэхээр зорьж буй бүлэг хүмүүс эсвэл байгууллагыг хэлнэ. Энэ нь бүрдүүлэгч хэсгүүдээс хамгийн чухал бөгөөд дэлгэрэнгүй судлах хэсэг юм.

2. Хүргэх үнэ цэнэ - Тодорхойлон гаргасан хэрэглэгчийн сегмент тус бүрт нь нэг бүрчлэн хүргэж буй үнэ цэнүүд болон түүнийг хүргэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний багцыг илтгэнэ.

3. Сувгууд - Тодорхойлсон хэрэглэгчийн сегмент тус бүрт нь нэг бүрчлэн хэрхэн хүрч, санал болгож буй үнэ цэнээ хэрхэн хүргэж буй сувгийг харуулна.

4. Хэрэглэгчтэй тогтоох харилцаа - Тодорхойлсон хэрэглэгчийн сегмент тус бүрт нь нэг бүрчлэн тогтоосон харилцааны байдлыг харуулна.

5. Орлогын урсгал - Тодорхойлсон хэрэглэгчийн сегмент тус бүрээс компанид орж ирж буй мөнгөн урсгалыг харуулна.

6. Түлхүүр үйл ажиллагаа - Бизнес моделийг бүрэн ажиллахад буюу үнэ цэнийг бий болгоход шаардлагатай нэн чухал, хийгдэх ёстой зүйлсийг хэлнэ.

7. Түлхүүр нөөц - Бизнес моделийг бүрэн ажиллахад буюу үнэ цэнийг бий болгоход шаардлагатай нэн чухал өмч, хөрөнгийг хэлнэ.

8. Түлхүүр түншүүд - Бизнес моделийг бүрэн ажиллахад шаардлагатай нийлүүлэгч, түншүүдийн сүлжээг хэлнэ.

9. Өртөг зардын бүтэц - Бизнес моделтой холбоотой бүхий л өртөг зардлыг илэрхийлнэ.

9. REACH ТӨСЛИЙН 1 САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

- 2017.01.04-06 болон
- 2017.01.17-19-нд Улаанбаатар хот “Бизнес Төсөл Боловсруулах Аргачлал”, “Санхүүгийн Тайланг Уншиж ойлгох нь”, “Санхүүгийн Тайлангийн Шинжилгээ ба Хэрэглээ”, “Зээлийн Боловсрол” сэдвээр сургалт
- 2017.01.12-нд ЖДБ-ийн Санхүүжилтийг дэмжих ажил хэрэгч уулзалт
- 2017.01.10 -13 Баян-Өлгий, Дундговь, Сэлэнгэ, Дорнод аймгуудад “Зээлийн боловсрол” сэдвээр сургалт
- 2017.01.09 -24 Баян-Өлгий, Дундговь, Сэлэнгэ, Дорнод аймгуудад ажил хэрэгч уулзалт

Та дээрх сургалт, уулзалтанд бүртгүүлэх бол:

- **Улаанбаатар Оффис:**
№: 703, МАКС Тауэр, Жуулчины гудамж 4-4, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Утас: 7722-2210, И-мэйл: reach@dsmongolia.org
- **Баян-Өлгий Салбар**
№ 302 тоот, Гурван-Эрдэнэ Төв 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг. Утас 7042-2080
- **Дундговь Салбар**
№ 205 тоот Мандал Шилтгээн ХХК-ийн байр, 7-р баг, Бага тойруу, Сайнцагаан Сум, Дундговь аймаг. Утас 7059-2209
- **Дорнод Салбар**
№11 тоот, Олъхон Худалдааны Төв, 9-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг. Утас 7058-2030
- **Сэлэнгэ Салбар**
№1 тоот, Алтан Булаг Төв, Сүхбаатар сум, 2-р Сэлэнгэ аймаг. Утас 7036-3440

“Энэхүү сонинийг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-аар дамжуулан Америкийн ард түмний өгөөмөр дэмжлэгтэйгээр бүтээсэн болно. Хөгжлийн Шийдэл ТББ нь сонинтой холбоотой хариуцлагыг бүрэн хүлээх бөгөөд үүнд АНУ-ын Засгийн Газар болон АНУ-ын ОУХА-ийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.”